

ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХЭТИЙН ТӨЛӨВ БА МОНГОЛ УЛС

Д.Тунгалаг *

Олон улсын аялал жуулчлал нь гадаадын жуулчдын соёлын болон оюун санааны хэрэгцээг хангах, чөлөөт цагаа зөв боловсон амарч өнгөрүүлэх зорилготой бөгөөд эрэлт хэрэгцээ ихтэй жуулчны бараа болон төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа билээ. Өнөө үед дэлхийн улс орнуудын хэмжээнд тээвэр, холбооны салбар өндөр хурдацтай хөгжиж, хүмүүс чөлөөт цагаа аялан зугаалж, амарч өнгөрөөх сонирхол нэмэгдсэн, улс орнуудын ард түмний амьдралын түвшин дээшилж нийгмийн амьдралын хүрээ олон улсын шинж чанартай болж байгаатай холбоотойгоор олон улсын аялал жуулчлал хөгжлийнхөө шинэ эрин үед ороод байна гэж хэлж болохоор байна.

Аялал жуулчлал нь ард түмнийг харилцан ойлголцуулахаас гадна нийгэм-эдийн засаг, шинжлэх ухаан, соёлын хамтын ажиллагааг өргөжүүлж, улс орны нийгэм-эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг үйлдвэрлэлийн салбар юм.

Дэлхийн I дайнаас хойш аялал жуулчлал маш эрчимтэй хөгжиж эхэлсэн. 1919 онд Газрын дундад тэнгисийн орнууд голлож Олон улсын жуулчдын агентлагийг Париж хотноо байгуулснаар Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын (ДАЖБ) эхлэл тавигдсан юм. Олон улсын аялал жуулчлын хөгжлийн цэцэглэлтийг 1950 оноос эхэлсэн гэж үздэг бөгөөд ДАЖБ-ын эрхэм зорилт нь аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар дэлхийн эдийн засгийг хөгжүүлэх, олон улсын харилцан ойлголцлыг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалах, хүний эрхийг дээдлэн хүндэтгэж хамгаалахад нөлөөлөх явдал юм.

Өнөөгийн байдлаар АНУ, Европын орнуудад уг салбар илүү түргэн хурдацтай хөгжиж улмаар улс орныхоо эдийн засгийг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсаар байна. Сүүлийн

* МУИС, ОУХС-ийн проф. доктор (Ph.D)

хорь гаруй жилийн хугацаанд олон улсын жуулчдын тоо дэлхийд гуравны нэгээр нэмэгдэж түүний өсөлт жилд дунджаар 4,5-5% болж байна. Үүнд аялал жуулчлалын салбарт нийгмийн шинэ давхаргыг (тэтгэврийнхэн, жижиг үйлдвэрийн эзэд, гэр бүлийн аялал) татан оролцуулах болсон, холбоо болон техникийн хэрэгсэл боловсронгуй болж сайжирсан, иргэдийн хувийн орлого хангалттай өссөн зэрэг хүчин зүйлүүд нөлөөлсөн гэж үзэж болно. Түүнчлэн дэлхийн улс орнууд олон улсын хөдөлмөрийн хуваарьт идэвхтэй оролцон өөрсдийн нөөц баялгийг оновчтой ашиглаж жуулчдад бараа үйлчилгээг чанартай үзүүлж байгаа, аялал жуулчлалыг валютын орлогын үр ашигтай эх сурвалж болгож байгаатай шууд холбоотой.

ДАЖБ, ДХБ-ын судалгаагаар өнөөдөр дэлхий дээр жилд 500 сая орчим хүн хилийн чанадад аялал жуулчлалд хамрагдаж байна гэсэн тооцоо гарчээ. Агаарын тээврээс эхлэн техник технологийн өндөр хөгжил нь аялал жуулчлалыг хөгжүүлэх чухал суурь болж байна. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлснээр дэлхийн олон орны хүмүүс бусад орны хүмүүстэй соёлын харилцаагаа өргөжүүлэхийн зэрэгцээ байгаль орчин, хүн төрөлхтний хуримтлуулж ирсэн соёлын үнэт өвийг сонирхон судлах боломжтой болж байгаа юм.

Улс орны эдийн засгийг өндөр хурдацтай хөгжүүлэх, шинээр үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд ихээхэн ашиг тустай тул аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахыг хүмүүс ихэд эрмэлзэх болжээ. Ингэснээр дэлхийн олон орнууд энэхүү салбарт өрсөлдөн аялал жуулчлал хөгжлийн тодорхой түвшинд хүрээд байна.

2003 оны байдлаар дэлхийн шилдэг аялал жуулчлалын чиглэл улсууд болон аялал жуулчлалаас хамгийн их ашиг олсон орнуудыг дараах хүснэгтэнд үзүүлэв.

**Дэлхийн шилдэг аялал жуулчлалын чиглэл улсууд
(2003 оны байдлаар)**

Байр	Улс	Жуулчдын тоо (сая)	Дэлхийн зах зээлд эзлэх хувь
1	Франц	75.0	10.8
2	Испани	52.5	7.6
3	АНУ	40.4	5.8
4	Итали	39.6	5.7
5	Хятад (PRC)	33.0	4.8
6	Англи	24.8	3.6
7	Австрали	19.1	2.8
8	Мехсик	18.7	2.7
9	Герман	18.4	2.7
10	Канад	17.5	2.5

**Дэлхийд аялал жуулчлалаас хамгийн их ашиг олсон улсууд
(2003 оны байдлаар)**

Байр	Улс	Аялал жуулчлалаас олсон орлого (тэрбум ам.дол)	Дэлхийн зах зээлд эзлэх хувь
1	АНУ	65.1	12.7
2	Испани	41.7	8.1
3	Франц	36.6	7.1
4	Итали	31.3	6.1
5	Герман	23.0	4.5
6	Англи	19.4	3.8
7	Хятад	17.4	3.4
8	Австрали	13.6	2.6
9	Турк	13.2	2.6
10	Грек	10.7	2.1

2003 онд дэлхийн аялал жуулчлалын салбарын хөгжилд Иракийн хямрал, дэлхийн эдийн засгийн тогтворгүй байдал, Азийн ханиад өвчин зэрэг томоохон бэрхшээл учирч 2002 онтой харьцуулахад аялал жуулчлал дэлхийн хэмжээнд 1,2 хувиар багассан нь дэлхийн аялал жуулчлалын түүхэнд нэг жилийн дотор гарсан хамгийн их уналт гэж ДАЖБ-аас тодорхойлсон байна.

Мөн ХХI зуунд дэлхийн аялал жуулчлалыг хөгжүүлэх 5 голлох чиглэлийг тогтоожээ.

Үүнд:

- Адал явдалт аялал жуулчлал - Adventure tour (ууланд авирах, агаарын бөмбөлгөөр аялах, салаар аялах аялал);
- Экотуризм - Ecotourism (явган аялах, байгаль үзэх, шувуу сонирхох, фото аялал);
- Тусгай сонирхлын аялал - Special interest tour (тэмээн, эмчилгээний, шавьж цуглуулах аялал);
- Тойрон аялал - Round trip (далайн, улс дамнасан, хотын аялал);
- Соёл-танин мэдэхүйн сэдэвт аялал - Culture tour (соёлын археологийн, музей).

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын судалгаанаас харахад 2020 онд жуулчдын тоо 1995 оныхтой харьцуулахад 3 дахин нэмэгдэж 1,6 тэрбум ам.долларт хүрэх бөгөөд Ази, Номхон далайн бүс нутагт аялах жуулчдын тоо дэлхийн бүсүүдээс илүү хурдацтай нэмэгдэнэ гэж судлаачид үзэж байна. Мөн манай хөрш хоёр оронд 2020 он гэхэд 250 орчим сая жуулчин ирэх магадлалтай гэсэн байна. Түүнчлэн БНХАУ-д ирэх жуулчдын тоо жил бүр 8 хувиар өснө гэсэн судалгаа ч гарчээ. Энэ нь Монголд ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх таатай боломж юм.

Иймд хөрш орнуудтай аялал жуулчлалын зах зээл дээр идэвхтэй хамтран ажиллах шаардлагатай байгаа юм.

Ирэх 20 жилд Герман, Япон, АНУ, БНХАУ, Англи, ОХУ-ын иргэд гадаадад хамгийн их жуулчлана гэж үзэж байгаа. Аялал жуулчлал эдийн засгийн өсөлт, хувь хүмүүсийн орлогын хэмжээнээс шууд хамааралтай бөгөөд хувь хүмүүсийн орлого 2,5 хувиар өсөхөд аяллын зардал 4 хувиар өсдөг болохыг судлаачид тогтоосон байна.

Мэдээлэл холбооны технологи аялал жуулчлалын салбарт хүчтэй нэвтэрч байгаатай холбогдож тур оператор, тур агентийн гүйцэтгэх үүрэг роль ихээхэн өөрчлөгдөж эхэллээ. Аялал жуулчлал нэг орноос хальж улам бүр олон улсын шинжтэй улс үндэстэн дамжсан хоршсон үйлчилгээний шинжтэй болж байгаа нь аялал зохион байгуулах, жуулчдаас бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан авах, үнэ бүрдэлтийн хүчин зүйлд өөрчлөлт орох шалтгаан болж үүнийг дагаад аяллын өртөг хямдрах хандлагатай байна. Өөрөөр хэлбэл дэлхийн аялал жуулчлалын салбар глобалчлалын үйл явцад идэвхтэй хамрагдаж байна гэсэн үг. Зочид буудал, ресторан, түргэн хоол, тээврийн үйлчилгээнд олон улсын корпораци, сүлжээнүүд тодорхой байр сууриа нэгэнт эзэлжээ. Одоогийн байдлаар эдгээр сүлжээнүүд гол төлөв АНУ, Баруун Европ, Япон, Хонгконгод байршиж хүрээгээ өргөжүүлсээр байна.

Аялал жуулчлал нь улс төр, эдийн засгийн хямрал, дайн дажин, ядуурал, байгалийн гамшиг, халдварт өвчин, олон улсын терроризм зэрэг урьдчилан таамаглах боломжгүй хүчин зүйлээс шууд хамааралтай ихээхэн эмзэг салбар болохыг өнгөрсөн жилийн үйл явдлууд харуулж, түүнийг хохирол багатайгаар гэтлэн давж урьдчилан сэргийлэхэд улс орнууд хэзээ хэзээнээс илүү хамтран ажиллах хэрэгтэй болж байна.

Манай улс зах зээлийн эдийн засагт шилжин орсноор эдийн засгийн олон салбарууд эрчимтэй хөгжиж эхэлсний нэг нь аялал жуулчлалын салбар юм.

Монгол улс үндэсний аялал жуулчлалыг дэлхий дахины нийтлэг хандлага болж буй экологийн баримжаатай, эдийн засгийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн өндөр үр ашигтай, биеэ даасан салбарын хэмжээнд хүргэж хөгжүүлэх нь аялал жуулчлалын талаар баримтлах үндсэн чиглэл болж байна.

Монгол орон нүүдлийн соёл иргэншил, ард түмний өвөрмөц зан заншил, аж төрөх ёс, түүх, соёл, археологийн ховор нандин дурсгал, харьцангуй унаган төрхөөрөө хадгалагдан үлдсэн үзэсгэлэнт байгаль, цэвэр агаар зэрэг онцлогтой орны хувьд аялал жуулчлалыг

хөгжүүлэх замаар үндэсний орлогоо нэмэгдүүлэх, ард иргэдээ ажлын байртай болгох, улмаар тэдний амьжиргааны түвшинг дээшлүүлэх тааламжтай нөхцөл бүрдсэн орон гэж үздэг. Гэвч тус оронд аялал жуулчлалын байгууллага үүсч бий болоод 50-иад жил болж байгаа хэдий ч аялал жуулчлалын хөгжлийн одоогийн түвшин нь өнөөгийн орчин үеийн шаардлагыг хангах хэмжээнд хүрч чадаагүй байгаагаас гадна улс орны эдийн засагт нөлөөлөх салбар болж хөгжих хэмжээнд хүрээгүй байна.

Тийм ч учраас сүүлийн жилүүдэд Монгол улсын Засгийн газраас аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар ихээхэн анхаарч 1995-2005 онд аялал жуулчлалын талаар баримтлах үндсэн чиглэлийг тодорхойлж энэ ажлын хүрээнд Монгол улсад аялал жуулчлалыг 2015 он хүртэл хөгжүүлэх Мастер төлөвлөгөөг Европын Холбоо болон Япон улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр боловсруулсан билээ. Уг төлөвлөгөөнд байгалийн болон соёл, түүхийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах, аялал жуулчлалын салбарын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог бэхжүүлж үйлчилгээний соёл, чанарыг дэлхийн түвшинд хүргэх, хүний нөөцийг хөгжүүлэх замаар үндэсний аялал жуулчлалыг хөгжүүлэх ерөнхий стратегийг тодорхойлсон юм.

Мөн зах зээлийн тогтолцооны нөхцөлд аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн таатай орчин бүрдүүлэх шаардлагын үүднээс 2000 онд Аялал жуулчлалын тухай Монгол улсын хуулийг УИХ-аар баталснаас гадна аялал жуулчлалын ажил үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд эдийн засгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор тэдгээрийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн ба манай улсад 30 хоногийн дотор аялагчдыг холбогдох байгууллагад бүртгүүлэхгүй байхаар шийдэж, визийн хөнгөлөлтийн асуудлаар зарим улс орнуудтай тохиролцоонд хүрч байгаа зэрэг нь аялал жуулчлалын хөгжилд бодитой дэмжлэг үзүүлж байгаа төрийн бодлогын илрэл юм.

Эдгээр арга хэмжээ болон аялал жуулчлалын ажил үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжүүд, төрийн бус байгууллагуудын хүчин чармайлтын үр дүнд сүүлийн жилүүдэд Монголд зочилж буй гийчин жуулчдын тоо жил бүр дунджаар 15-20 хувиар тогтмол нэмэгдэх боллоо.

1990 оноос өмнө Монголд ихэвчлэн ОХУ, Зүүн болон Төв Европын орнуудаас жуулчид ирдэг байсан бол 1990-ээд оноос хойш жуулчдын тоо огцом өссөн бөгөөд дийлэнх нь Хятад, Орос, Өмнөд Солонгос, Япон, АНУ, Герман, Англи, Франц зэрэг улсаас ирсэн жуулчид

байна. Энэ нь манай улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих үед хувийн аялал жуулчлалын компаниуд маш олноор байгуулагдсантай холбоотой.

Сүүлийн жилүүдэд манай оронд ирэх жуулчдын тоо нэмэгдэж, аялал жуулчлалын салбараас олох орлого өсч ДНБ-ний 10 орчим хувийг эзэлж байна гэсэн тооцоо гаргажээ.

Монгол улсад ирсэн жуулчдын тоо, аялал жуулчлалын орлого

Бүс, улс	2004	2005	Өсөлт (тоо)	Өсөлт (хувь)
<i>Жуулчид (бүс нутгаар)</i>				
Африк	253	299	+46	+18,1
Америк	11849	12323	+474	+4,0
Европ	93994	103694	+9700	+10,3
Зүүн Ази ба Номхон далайн орнууд	177734	203570	+25836	+14,5
өмнөд Ази	935	757	-178	-19,0
Ойрхи Дорнод	238	230	-8	-3,3
Бусад	19	20	+1	+5,2
Нийт	285022	320893	+35871	+12,5
<i>Жуулчид(улс орноор)</i>				
1. Хятад	130532	160155	+29623	+22,6
2. Орос	50234	53800	+3566	+7,0
3. Өмнөд Солонгос	25585	29748	+4163	+16,2
4. Япон	12736	12566	-170	-1,3
5. Америк	8609	9683	+1074	+12,4
6. Герман	9181	8039	-1142	-12,4
7. Их Британи	4819	5581	+762	+15,8
8. Франц	5500	5201	-299	-5,4
9. Казакстан	2904	3756	+852	+29,3
10.Австрали	2877	3320	+443	+15,3
Бусад	32045	29044	-3001	-9,3
<i>Аялал жуулчлалын орлого, сая ам.доллар</i>				
Орлого	174,3	193,1	+18,8	+10,7

Эх сурвалж: Хил Хамгаалах Ерөнхий газрын мэдээлэл. 2005-12-20

Одоогийн байдлаар манай улсад 160 орчим жуулчны бааз, 300 орчим зочид буудал үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 12 мянга орчим хүнийг ажлын байраар хангаж улмаар энэ тоо цаашид өсөх хандлагатай байгаа билээ.

Манай улсын аялал жуулчлалын салбарт дээр дурьдсан зарим ахиц гарч байгаа ч салбарын өмнө шийдвэрлэвэл зохих олон асуудал байна.

Монгол орон Азийн төв хэсэгт оршдог, далай тэнгисээс ихээхэн алслагдсан, эх газрын эрс тэс хүйтэн уур амьсгал нь аялал жуулчлалын улирлыг богиносгож буй гол шалтгаан болдгоос гадна өөрийн орныг гадаадад сурталчлах ажил шаардлагын хэмжээнд хийгдэхгүй

байгаа нь тус улсад аялал жуулчлалыг цаашид хөгжүүлэхэд муугаар нөлөөлж байна. Мөн газар шороог энд тэндгүй эмх замбараагүй ухаж элдэв хорт хийгээр агаарыг бохирдуулах, ой модыг хайр найргүй огтлох зэргээр байгаль орчныг сүйтгэж байгаа, түүнчлэн жуулчдын баазын амьдрах байр сав тохигүй, тав тухтай амрах наад захын хэрэгцээг хангахгүй, бие засах газрыг шаардлагын түвшинд тэр болгон байлгаж чадахгүй байгаа нь гадаадын жуулчдыг ихээр татаж чадахгүй байгаа асуудалд юунаас ч илүү нөлөөлж буй чухал хүчин зүйл гэж боддог.

Иймээс гадаадын жуулчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээний соёл, чанарыг дээшлүүлж олон улсын түвшинд хүргэх, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, гадаадад сурталчлах ажлыг эрчимтэй хийх, аялал жуулчлалын салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татах, жуулчдын аюулгүй байдлыг хангах, эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулах, авто болон агаарын тээврийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хот суурин газар болон тусгай хамгаалалтын газрыг хог бохирдлоос цэвэрлэх, агаарын бохирдлыг бууруулах, бүх төрлийн үзвэр үйлчилгээ, соёлын газруудын ариун цэврийг сайжруулах, бие засдаг байрыг шинэчлэн тохижуулах зэрэгт анхаарлаа хандуулах нь нэн чухал шаардлагатай гэж үзэж байна.

Монголын аялал жуулчлалын салбарын хөгжилтэй уялдан мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх эрэлт хэрэгцээ нэмэгдлээ. Өнөөдрийн байдлаар төрийн болон хувийн 36 их, дээд сургуулиудад аялал жуулчлалын чиглэлээр бакалавр, магистрын зэрэг олгох сургалт явагдаж байна гэсэн судалгаа бий. Аялал жуулчлалын үйлчилгээ, чанарт тавигдах шаардлагатай уялдан уг салбарын мэргэжилтэн бэлтгэж байгаа их дээд сургуулиуд тооны төлөө бус чанартай сайн мэргэжилтэн бэлтгэхэд илүү анхаарах, сургалтын хөтөлбөрийг ижил төстэй гадаадын сургуулиудын жишгээр улам боловсронгуй болгох, багш нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх, аялал жуулчлалын салбарыг түлхүү хөгжүүлсэн олон улсын туршлагыг судлахад анхаарах хэрэгтэй байна. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд сайтар бэлтгэгдсэн боловсон хүчин шийдвэрлэх үүрэгтэйг аялал жуулчлал өндөр хөгжсөн орнуудын туршлага харуулж байгаа билээ.

Монголын “Швейцарь” гэж нэрлэгддэг Хөвсгөл нуур орчмын нутаг нь хол ойрын зочин гийчдийн сонирхлыг байнга татаж байдаг бөгөөд аялал жуулчлалын 20 гаруй бааз үйл ажиллагаа явуулж манай улсад амралт, аялал зугаалгын зорилгоор ирсэн жуулчдын 20 гаруй хувь нь энэ бүс нутагт аялж байна. Аялал жуулчлалын дэд бүтцийн хувьд агаарын, авто болон усан замын тээвэртэй, эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон давуу талтай бөгөөд

Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын салбарыг цаашид илүү хурдан хөгжүүлэн жуулчдын таатай аялах нөхцлийг ханган ажиллах нь манай орны аялал жуулчлал хөгжилд нэн чухал юм.

Монгол улсад өнөөдөр бүртгэгдсэн аялал жуулчлалын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах, чанарыг нь дээшлүүлэхэд анхаарлаа хандуулах хэрэгтэй байна.

Улс түмний хамтын ажиллагааг бэхжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ажлын байрыг ихээр бий болгодог, байгаль орчинд хор хөнөөл багатай хязгааргүй нөөцтэй “утаагүй үйлдвэрлэл” болохын хувьд аялал жуулчлалыг Монгол улсын эдийн засгийн нэг гол салбар болон хөгжүүлэх нь туйлын чухал асуудал болж байгаа бөгөөд Монгол улсын аялал жуулчлалын салбарт ойрын ирээдүйд мэдэгдэхүйц өөрчлөлт гарна гэдэгт итгэж байна.